



© UN Photo / Martine Perret

ХАРИУЦЛАГАТАЙ ХЭРЭГЛЭЭ БА ХАРИУЦЛАГАТАЙ ҮЙЛДВЭРЛЭЛ: ЯАГААД ЧУХАЛ ГЭЖ

Ямар зорилго дэвшүүлж байна вэ?

Тогтвортой хэрэглээ ба тогтвортой үйлдвэрлэлийн хэв маягийг дэмжих

Яагаад?

Ирэх хорин жилд дэлхий даяар илүү олон хүн дундаж давхаргад шилжих төлөвтэй байна. Энэ нь хувь хүний

хувьд илүү боломж боловч аль хэдийн шавхагдаад байгаа байгалийн нөөцийн хэрэгцээг улам ихэсгэнэ. Хэрэв бид өөрсдийнхөө хэрэглээг өөрчлөх талаар ямар нэг зүйл хийхгүй бол байгаль орчиндоо бид эргэж буцалтгүй хор хохирол учруулах юм.

Одоогийн хэрэглээний болон үйлдвэрлэлийн хэв маягт ямар өөрчлөлтүүд хийх хэрэгтэй вэ?

12

ХАРИУЦЛАГАТАЙ
ХЭРЭГЛЭЭ БА
ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ
ДЭМЖИХ



Дэлхийн хүн ам
2050 он

гэхэд
9,6 тэрбумд

хүрэх ба энэ
нь одоогийн
бидний

амьдралын
хэв маягийг

ТЭТГЭЖ

буй дэлхий шиг

гурван гариг

хэрэгтэй гэсэн

үг юм.

Хэрэглээндээ хамгийн энгийн өөрчлөлтийг хийснээр нийгэмд маш том нөлөө үзүүлэх олон аргууд байдаг. Жишээ нь жил бүр боловсруулсан нийт хүнсний гуравны нэг буюу 1 триллион доллартай тэнцэх 1,3 тэрбум тон хүнс нь хэрэглэгч эсвэл жижиглэн худалдаалагчдын хогийн саванд муудаж, эсвэл бизнесийнхний шийдэх ёстой асуудал болох зохисгүй тээвэрлэлт болон ургац хураалт зэрэг шалтгаанаас мууддаг.

Хэрэглэгчийн хувьд өрхүүд дэлхийн эрчим хүчний 29 хувийг хэрэглэдэг ба CO₂-н 21 хувийг ялгаруулдаг. Гэхдээ хэрэв дэлхий даяар хүмүүс эрчим хүчинд хэмнэлттэй гэрлийн шил хэрэглэж эхэлбэл дэлхий нийтээр жил бүр 120 тэрбум америк доллар хэмнэнэ. Усны бохирдол нь мөн тогтвортой шийдэлд хүрэх чухал асуудал болоод байна. Бид гол горхи, нуурын усыг байгаль өөрөө цэвэршүүлдэг тэр хурднаас илүү хурдтай бохирдуулж байна.

Би бизнес эрхлэгчийн хувьд хэрхэн тусалж болох вэ?

Тогтвортой хэрэглээ болон үйлдвэрлэлийн хэв маягийг дэмжих шинэ шийдлийг олох нь бизнес эрхлэгчийн сонирхолтой нийцдэг. Хэрэгцээтэй байгаа бүтээгдэхүүн үйлчилгээний байгаль орчны болон нийгмийн үр нөлөө, үүнд

бүтээгдэхүүний цикл болон эдгээр үр нөлөө нь бүтээгдэхүүний хэрэглээний циклийн туршид хэрхэн өөрчлөгдөхийг илүү сайн ойлгох шаардлагатай. Нэмүү өртгийн сүлжээн дэх байгаль орчин болон нийгэмд хамгийн ихээр нөлөөлөх боломжтой “халуун цэгийг” тодорхойлох нь хамгийн эхний алхам юм. Бизнесүүд нь өөрсдийн шинэлэг санааг эрэлхийлэх чадварыг ашиглан хувь хүмүүст илүү тогтвортой амьдралын хэв маягийг сонгох сэдэл болон боломжийг бий болгох шийдийг санал болгож болно. Ингэснээрээ сөрөг үр дагаврыг багасгаж, хүмүүсийн сайн сайхан амьдрах нөхцлийг дээшлүүлэх юм.

Би хэрэглэгчийн хувьд хэрхэн тусалж болох вэ?

Энд хоёр гол арга байна.

1. Өөрийн хэрэглээнээс гарч буй хог хаягдлыг багасгах,
2. Худалдан авалт хийхдээ бодолтой хандаж ямар худалтан авалт хийхээ шийдэх, боломжтой үед экологийн тогтвортой хувилбарыг сонгох.

Бид өөрсдийн хог хаягдлыг олон аргаар багасгаж болно. Үүнд хоол хүнсийг хог хаягдал болгохгүй байхаас эхлээд байгаль, далай тэнгэсийг бохирдуулагч гол бүтээгдэхүүн болох хуванцар уутыг хэрэглэхгүй байх зэрэг байж болно.

Дахин хэрэглэдэг уут авч явах, хуванцар соруул хэрэглэхээс татгалзах, хуванцар ундааны савыг дахин хэрэглэх зэрэг нь өдөр бүр таны оруулж болох сайн хувь нэмэр болно. Худалдан авалт хийхдээ юу худалдаж авч байгаа талаараа мэдээлэлтэй байх нь бас нэг төрлийн хувь нэмэр юм. Жишээ нь сүлжмэлийн үйлдвэрлэл нь өнөөдөр усыг бохирдуулдагаараа хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн дараа хоёрдугаарт ордог салбар ба үйлдвэрлэл нь хөгжиж буй улс орнуудын сүлжмэлийн үйлдвэрийн ажилчдыг мөлжлөгт өртүүлдэг салбар юм. Хэрэв та орон нутгаасаа экологийн тогтвортой эх сурвалжаас худалдан авалт хийвэл бизнесүүдэд тогтвортой практикийг авч ашиглахад нь шахалт үзүүлж, байгаль орчныг хамгаалахад хувь нэмрээ оруулж байна гэсэн үг юм.

Зорилт 12-ын талаар болон бусад Тогтвортой Хөгжлийн Зорилтуудын талаар дэлгэрэнгүй мэдээллийг дараах вебсайтаас харна уу:

<http://www.un.org/sustainabledevelopment>



SUSTAINABLE DEVELOPMENT GOALS

17 GOALS TO TRANSFORM OUR WORLD